

ТОЙМ



**ОЛОН УЛСЫН
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2025.02.27

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- S&P 500 индекс пүрэв гарагт шинэ дээд амжилт тогтоосон ч баасан гарагт буурсан.
- Дональд Трамп эхний өдөр тариф нэмэхээс татгалзаж, зах зээлд эерэг нөлөө үзүүлэв.
- Softbank, OpenAI, Oracle, MGX-ийн хамтарсан "Stargate" төсөл 500 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт зарласан нь AI хувьцаанууд өслөө.
- S&P 500 компанийн 76% нь ашгийн таамаглалыг давуулж, жилийн ашгийн өсөлт 12.7%-д хүрэхээр байна.
- Хятадын PMI индекс 50-с бага буюу агшилтын бүсэд шилжиж, АНУ-ын тариф нэмэгдэх эрсдэл өндөр хэвээр байна.

2025 он 01-р сарын 27

Dow Jones	44,424.25
S&P 500	6,101.24
Nasdaq	19,954.30
DAX	21,148.01
FTSE 100	8,467.93
S&P/ASX 200	8,408.90
HANG SENG	20,165.75

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	-0.32%	2.15%	3.33%	4.42%	16.57%	27.93%
S&P 500	0.00%	1.74%	2.18%	3.73%	24.74%	37.67%
Nasdaq	-0.50%	1.65%	1.18%	3.33%	29.11%	44.91%

2025 оны 01 сарын 27-ны 11:00

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	-1.15%	0.88%	5.95%	6.35%	24.84%	38.22%
FTSE 100	-0.44%	-0.56%	3.96%	3.66%	10.97%	13.48%

2025 оны 01 сарын 27-ны 11:00

Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.36%	0.74%	1.78%	3.06%	11.30%	20.33%
Hang Seng	0.50%	1.20%	0.37%	0.53%	26.41%	-14.37%

2025 оны 01 сарын 27-ны 11:00

S&P 500 индексийн
2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Wells Fargo	6,500
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678



Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Өнгөрсөн долоо хоногт гол индексүүд өсөлт үзүүлж, S&P500 индекс пүрэв гарагт шинэ дээд амжилт тогтоосон ч баасан гарагт уналттай хаагдлаа. Growth төрлийн хувьцаанууд value төрлийн хувьцаанаас өсөлтөөрөө давлаа. Өнгөрсөн долоо хоногийн гол анхаарал хандуулах үйл явдал нь АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын албан ёсны тангараг өргөх ёслол ба түүнийг дагасан улс төрийн үйл явдлууд байлаа. Трамп ажлаа авсан эхний өдөр шууд тариф нэмэхээс татгалзаж, худалдааны бодлогыг судлах үүрэг өгсөн нь зах зээлийн өсөх хандлагыг дэмжлээ. Мөн Трамп Softbank, OpenAI, Oracle, MGX-тэй хамтран "Stargate" хөтөлбөрийг зарлаж, тус хөтөлбөрийн хүрээнд АНУ-д хиймэл оюун ухааны дэд бүтцэд зориулж 500 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр болсон нь AI-тэй холбоотой хувьцаануудын өсөлтөд нөлөөлсөн байна.

Үйлдвэрлэл сэргэж, хэрэглэгчдийн итгэл буурав

Нэгдүгээр сард АНУ-ын үйлдвэрлэлийн салбар зургаан сарын дараа анх удаа өсөлт үзүүлсэн бол үйлчилгээний салбарын өсөлт удааширсан байна. Хэрэглэгчдийн итгэлийн индекс 74.0-өөс 71.1 болж буурсан нь инфляцын хүлээлт, ажилгүйдлийн талаархи санаа зовнилтой холбоотой аж. Ийнхүү үйлдвэрийн салбарын хүлээлт сэргэсэн нь индексийн ханш өнгөрсөн долоо хоногт өсөхөд нөлөөлжээ.

АНУ-ын тайлангаа зарласан компаниудын 78% нь шинжээчдийн таамаглалын давлаа

S&P 500 индексийн дөрөвдүгээр улирлын тайлангаа гаргасан компаниудын 76% нь шинжээчдийн таамгийг давуулж, дунджаар 7.4%-иар ашгийн хүлээлтийг давсан өсөлт үзүүлжээ. Ашгийн өсөлт жилийн дүнгээр 12.7%-д хүрэх хүлээлттэй байгаа бөгөөд 11 салбараас 7 нь 2024 онд ашиг нь өсөхөөр таамаглагдаж байна. Ашиг буурах хүлээлттэй байгаа салбарууд (хэрэглээний бүтээгдэхүүн, эрчим хүч, үйлдвэрлэл, түүхий эдийн салбар) нийт S&P 500-ийн зах зээлийн үнэлгээний 19%-ийг эзэлж байна.

График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал

Golomt Capital published on TradingView.com, Jan 27, 2025 03:10 UTC-5

US 500, 1D, CAPITALCOM O6,069.0 H6,071.9 L5,995.0 C5,998.6 -99.5 (-1.63%) -99.5 (-1.63%)





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хятадын үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаа нэгдүгээр сарын урьдчилан таамаглалаар буурсан тухай Худалдан авах менежерүүдийн индекс (PMI)-ийн даваа гарагт нийтлэгдсэн мэдээлэл харууллаа. Учир нь орон нутгийн аж ахуйн нэгжүүд Бээжингийн сүүлийн үеийн эдийн засгийн идэвхжүүлэлтийн арга хэмжээнүүдээс зөвхөн богино хугацааны дэмжлэг авсан байна. Харин үйлдвэрлэлийн бус салбарын өсөлт ч мөн нэгдүгээр сард огцом удааширч, АНУ-ын худалдааны тариф өсөх магадлал өндөр байгаа нь орон нутгийн бизнесүүдэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Үйлдвэрлэлийн PMI нэгдүгээр сард 49.1 болж буурсан нь өмнөх сарын 50.1 дээр тогтвортой хадгалагдана гэсэн таамаглалаас доогуур үзүүлэлт болов. PMI-ийн хэмжээ 50-иас доош орсон нь салбарын идэвх буурч буйг илтгэдэг бөгөөд үйлдвэрлэлийн PMI 3 сар дарааллан өссөн ч энэ сар агшилтын бүсэд шилжлээ. Үйлдвэрлэлийн бус PMI 50.2 болж унасан нь 12 дугаар сарын 52.2-оос ихээхэн доогуур байв. Үүний үр дүнд Хятадын нийлмэл PMI 50.1 болж, таамаглаж байсан 52.1 болон өнгөрсөн 12 дугаар сарын 52.2-оос нэлээд доогуур түвшинд гарлаа.

Даваа гарагт нийтлэгдсэн энэхүү PMI-ийн үзүүлэлт нь 2024 оны сүүл хүртэлх хугацаанд Бээжингийн хэрэгжүүлсэн олон төрлийн хүчтэй идэвхжүүлэлтийн арга хэмжээ аж ахуйн нэгжүүдэд тодорхой дэмжлэг үзүүлсэн ч харьцангуй хүртээмж муутай байсныг харуулж, төрөөс нэмэлт арга хэмжээ авах шаардлагатайг онцолж байна. Уг мэдээлэл нь Сар шинийн баярын өмнөхөн гарсан бөгөөд баярын үеэр Хятадын зах зээл бараг нэг долоо хоног амардаг. Энэхүү баяр нь ихэвчлэн аялал, хэрэглээ нэмэгдэхтэй холбоотойгоор, ялангуяа үйлдвэрлэлийн бус салбарын орон нутгийн бизнесийн үйл ажиллагааг идэвхжүүлдэг.

Мөн даваа гарагт гарсан мэдээлэл нь АНУ-аас Хятадын эсрэг худалдааны тарифыг нэмэгдүүлэх вий гэсэн болгоомжлол улам өндөр болж буй үетэй давхцаж байна. АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп хоёрдугаар сарын 1-нээс эхлэн Хятадын бүх импортын бараанд 10 хувийн гаалийн татвар ногдуулах боломжтойг анхааруулсан. Трампын төлөвлөж буй тарифын нөлөөг сааруулахын тулд Хятад улс цаашид ч илүү өргөн хүрээтэй дэмжлэгийн арга хэмжээнүүдийг авна гэж үзэж байна.

График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал



ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

Хүснэгт 1: Энэ долоо хоногт зарлагдах онцлох мэдээнүүд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning January 20, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
		 Schwab	 Netflix	 P&G	 Kinder Morgan	 GE Aerospace	 Texas Instruments	 Verizon	
		 3M	 United	 Abbott	 Alcoa	 American Airlines	 Intuitive Surgical	 American Express	
		 D.R. Horton	 Interactive Brokers	 Johnson & Johnson	 Discover	 Fidelity Investments	 CSX	 Ericsson	
		 KeyBank	 Seagate	 Haliburton	 Horizon	 Texas Capital Bank	 East West Bank	 HCA Healthcare	
		 Fifth Third Bank	 Progress	 GE Vernova	 Steel Dynamics, Inc.	 Elevance Health	 Metropolitan Commercial Bank	 NextEra Energy	
		 Forestar	 Capital One	 Ally	 Knight-Ridder	 Alaska Airlines	 Source Capital Corporation	 First Citizens BancShares	
		 新东方	 Zions Bancorporation	 Amphenol	 RLI	 McCormick	 First Financial Bank	 Lake City Bank	
		 Prologis	 Great Southern Bank	 Travelers	 Cummins	 TAL	 Business First	 MOOG	
		 UMC	 Agilysys	 TE Connectivity	 Cadence	 LYTS	 Covenant	 South Plains Financial, Inc.	
		 Guaranty Bank & Trust	 Wintrust		 SL Green Realty Corp				
http://eps.sh/cal								© 2025 Earnings Whispers	

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning January 27, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
 SoFi	 NUCOR	 Boeing	 Starbucks	 ASML	 Tesla	 UPS	 Apple	 ExxonMobil	
 AT&T	 Berkley	 GM	 SAP	 Progressive	 Meta	 Mastercard	 Intel	 Abbvie	
 Bank of America	 Alexandria	 Lunar	 LendingClub	 T-Mobile	 Microsoft	 Dow	 VISA	 Chevron	
 Bank of Hawaii	 AGNC	 Royal Caribbean Group	 Logitech	 ADP	 Lam Research	 BK	 KLA	 Colgate-Palmolive	
 Dynex Capital Inc	 Brown & Brown	 RTX	 Stride	 VFC	 IBM	 Southwest	 CN	 Booz Allen Hamilton	
 Bank of Hope	 CRANE	 Synchrony	 PCSI	 teva	 servicenow	 NOKIA	 A Tlassian	 66	
 Oxford Lane	 Enterprise Financial	 JetBlue	 FIS	 DanaHER	 HNTI	 Caterpillar	 United States Steel	 Lyondellbasell	
 RYANAIR	 Walgreens	 Kimberly-Clark	 Chubb	 Brinker	 Celstica	 Allegro	 Baker Hughes	 Novartis	
	 SANMINA	 Sysco	 NextTracker	 General Dynamics	 Wolfspeed	 Comcast	 Deckers	 OneMain Financial	
	 Home Bank	 Commvault	 Stryker	 MSCI	 Waste Management	 in mobileye	 SkyWest	 Charter Communications	
http://eps.sh/cal								© 2025 Earnings Whispers	